

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

2022 оны II улирал хэрэгжилт /сумдад хамааралтай/

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Биелэлт (Хариуцах эзэн) | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|----------------|--------------|--|--|----------------------------|---|---|
| МУ-ын хууль | | | | | | |
| 1 | 1 | Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26 | 43.3.. Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. (43.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. 43.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан | Хамааралгүй ҮБ | | |

| | | | | | | |
|---|---|--|---|---|-----|--|
| | | | тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.) | | | |
| 2 | 2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 18.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэх, хүчирхийлэлд өртсөн гэр бүлийн гишүүнийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэхээр 4 зорилт, 9 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилтийн байдалд ЗДТГ, ИТХ, Хамтарсан багийн хяналтыг хийж, тухай бүрт соносоголыг авч хэлэлцдэг | 100 | |
| | 3 | | 18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Зардал төсвийг сумын Засаг даргын нөөц болон ГХУСЗардлаас гаргадаг. Ямар нэгэн төсөв батлуулаагүй. | 100 | |
| | 4 | | | | | |

| | | | | | |
|---|--|--|---|--|--|
| 5 | | <p>19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)</p> | <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг цахим болон танхимаар сурталчлах ажлыг 5удаа 845 хүнд хүргэсэн байна.</p> <p>100</p> | | |
| 6 | | <p>19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)</p> | <p>Сумын ИТХ-ын 2020.05.29 өдрийн 21 тогтоолоор хамтарсан багийн бүрэлдэхүүнийг засаг даргаар ахлуулан албан тушаалаар 11 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулсан.Одоогийн байдлаар ХЭХҮ-ний мэргэжилтэн, нийгмийн бодлогын мэргэжилтэн байхгүй байна. 100</p> | | |

| | | | | | | |
|----------------|----|---|---|--|--|--|
| | 7 | | 19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Түр хамгаалах байр байгуулах саналыг ИТХ-д тавиагүй. 0 | | |
| 3 | 8 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 15 ажлыг төлөвлөж, эхний хагас жилийн хэрэгжилтийг тооцоход 95,2%тай, ТАХ-ын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 11 ажил арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 85,0%тай дүгнэж үнэллээ. | | |
| 4 | 9 | Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01 | 8.1.. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно. | ИТХурал нь төлөөлөгчдийнхөө 2 удаагийн хурлаар малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын хураамжийн хувь хэмжээг тогтоон баталж улмаар ХЗЯаманд хүргүүлэн хянуулж батлуулснаар одоо дагаж мөрдөн хэрэгжүүлж байна. 100 | | |
| УИХ-ын тогтоол | | | | | | |
| 5 | 10 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 | 1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд | 2022 онд Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүүхэд хамгааллын сайн дурын 5 ажилтан томилогдсон. Сайн дурын ажилтнууд гэр бүлийн асуудалтай иргэдийн судалгааг гаргаж, хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд рүү чиглэсэн төрөл бүрийн | | |

| | | | | | | |
|--------------------------------|----|--|--|---|--|--|
| | | дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67 | хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:) | арга хэмжээнд идэвхитэй оролцдог. 100 | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | |
| 6 | 11 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалахад иргэд олон нийтийг татан оролцуулахаар гудамж хорооллын хэсгийн ахлагч, ААН байгууллагын ажилтантай хамтран ажиллаж байна. 70 | | |

| | | | | | | |
|-----------------------|----|---|---|--|----|--|
| | | 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 7 | 12 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Төрийн 5 байгууллага байгууллагын гадна , дотно өрөө, тасалгааны хаягийг крилл болон үндэсний бичгээр хослуулан бичсэн. Байгууллага бүрт монгол бичгийн сургалтыг зохион байгуулсан. | 70 | |

| | | | | | | |
|---|----|--|--|--|-----|--|
| | 13 | | 4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Сумын хэлний бодлогын салбар зөвлөлөөс төрийн байгууллагуудын нийт албан хаагчдын дунд "Монгол бичгээр хэн сайн бичих вэ " тэмцээн зарлаж, цээж бичиг, унших чадварын мэдлэг сорьж, монгол бичгийн үзэсгэлэн гаргасан. | | |
| | | | | 100 | | |
| 8 | 14 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох; | Аливаа нэг баяр ёслол, хүлээн авалтын арга хэмжээг зохион байгуулаагүй байна. Цаашид ч зохион байгуулаагүй, ЗГ-аас өгсөн үүрэг даалгавар чиглэлийг байгууллага бүрт хүргүүлэн хэрэгжүүлж ажиллаж байна. | | |
| | 15 | | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | Сумын хэмжээнд "Архигүй амьдралыг цогцлооё" уриалгыг Залуучуудын ТББ-аас нийт ард иргэддээ уриалан гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын фэйж хуудсаар хандсан хандалтын тоо-1880 | 100 | |

ЗГ-ЫН ТОГТООЛ

| | | | | | | |
|----|----|---|--|--|--|--|
| 9 | 16 | <p>ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257</p> | <p>2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.</p> | <p>Сумын хэмжээнд 263 өрх хөтөлж эхэлсэн ба 2022 онд 12 иргэнд угийн бичиг хөтлөх аргазүйн зөвлөгөө өгснөөр шинээр 5 өрх хөтөлж эхлээд байна. Ургийн бичгийг Шугаман хэлбэрээр -257 өрх, суварга- 2, цагираг-1, нарны цацраг -2, мод -1 хэлбэрээр хөтөлж байна.</p> <p>70</p> | | |
| 10 | 17 | <p>Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149</p> | <p>3.. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт</p> | <p>Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэн E-Mongolia ситемээр дамжуулан төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг иргэдэд түргэн шуурхай үзүүлэн эхний хагас жилд 104 иргэнд мэдээлэл лавлагаа олгоод байна. Мөн E-Mongolia хялбаршуулсан системийг иргэдэд сурталчилан ЗДТГ-ын үүдны хэсэгт видео сурталчилгааг иргэдэд ойлгомжтой байдлаар цацан мөн Төрийн албан хаагчдын нээлттэй хаалганы өдрөөр иргэдэд E-Mongolia системийг сурталчилав.</p> <p>100</p> | | |

| | | | | | | |
|----|----|---|---|---|--|--|
| | | | даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй. | | | |
| 11 | 18 | Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_18 | 4.. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Малын гаралтай түүхий эдийг хүлээн авах, хадгалах тээвэрлэх, борлуулах ажлыг иргэн Б.Бат-Эрдэнэ, З.Түвшинтөр нар гүйцэтгэж байна. Өөрсдийн хөрөнгөөр хадгалах, бэлтгэх байрыг бий болгож, хамтран ажиллах хувь хүн, компанитай холбоотой ажилладаг. Мөн Ширээс хоршооны гишүүдийнхээ олонхийн саналаар ноосыг худалдан авч, эсгийн үйлдвэрлэн зэргэлдээ аймаг сумдад борлуулт хийдэг. Эсгийний захиалга ихтэй. Худалдан авалт сайтай 100 | | |

Хэрэгжилт: 1-ҮБ, 2-80, 3-85, 4- 100, 5-100, 6-70, 7-85, 8-100, 9-70, 10-100, 11-100

дундаж 89%тай

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

С.НАРАНТУНГАЛАГ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2022 ОНД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМАНД ХАМААРАЛТАЙ ЗААЛТЫН 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ

2022.03.30

| № | Захирам жийн дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Заалты н дугаар | Заалт | Хариуцан хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжилт, үр дүн | Хувь |
|---|---------------------------|--|-----------------------|--|--|---|------|
| 1 | A/01 | “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2022.01.05 | 1 | 4. “Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), 2022 оны ажлын төлөвлөгөөндөө зорилт арга хэмжээ тусган шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг төрийн байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | ЗДТГ-ын дарга | “Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн 2022 оны төлөвлөгөөг 5 зорилт, 11 арга хэмжээг төлөвлөж батлууллаа. Энэхүү ажлын хүрээнд ЗДТГ нь байгууллагын соёл-харилцаа хандлага сэдэвт сургалт арга хэмжээг зохион байгуулж, 15 албан хаагч хамрагдлаа. Мөн Албан хаагчдыг сургах, нийгмийн баталгааг хангах жилийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажиллаж эхлээд байна. | 70 |
| 2 | A/77 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай 2022.02.28 | 23 | 2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжид хуулийн дагуу олгон, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), тухайн сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | БОХУБайцаагч | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын гэрээг 1 ААН-д 2019 онд олгосон. Хяналтанд авч ажиллаж байна. | 100 |
| 3 | A/98 | Электрон тамхи худалдан борлуулахыг хориглох тухай 2022.03.11 | 31 | 2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. | | Тамхи худалдаалах зөвшөөрөл бүхий 4 ААН-ээр орж хяналт тавин ажиллалаа. Электрон тамхи худалдаалдаг газар байхгүй байна. Цаашид хяналтанд авч байнаг хяналт тавьж ажиллана. | 100 |
| 4 | A/99 | | 32 | 4. Гарсан шийдвэрийг холбогдох | | Архи, согтууруулах ундаа худалдах | 100 |

| | | | | | | | |
|--|--|---|--|--|--|--|--|
| | | <p>Архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох тухай 2022.03.14</p> | | <p>газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар(Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> | | <p>тусгай зөвшөөрлийн эрхтэй 5 ААН-д сар бүр хяналт тавьж ажиллаж байна. Цагийн хуваарийн дагуу ажиллаж, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар байнга хяналт тавьж ажилладаг. Ямар нэг гомдол маргаан ирээгүй.</p> | |
|--|--|---|--|--|--|--|--|

Хэрэгжилт 3-100, 1-70 92,5%

Хэрэгжилт гаргасан: ЗДТГ-ын дарга

С.Нарантунгалаг